

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН
ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ҮР ӨГӨӨЖ

АУДИТЫН КОД: БНА-2023/25-3-ШТА-ГА

ХӨДӨӨ, АЖ АХУЙН САЛБАРТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН
САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД ОРОН НУТАГТ ТОДОРХОЙ
ХЭМЖЭЭНИЙ ҮР ӨГӨӨЖИЙГ ӨГСӨН БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор **Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер **А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор **Б.Должмаа**

Утас: 88110538 цахим хуудас: doljmaab@audit.gov.mn

Аудитор **Б.Нарангэрэл**

Утас: 99009293 цахим хуудас: narangerelb@audit.gov.mn

Аудитор **Н.Батчимэг**

Утас: 91113253 цахим хуудас: batchimegn@audit.gov.mn

Баянхонгор хот 2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/19

Номгон

Г Гүйцэтгэлийн аудитын тайлан Г
Баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж" (БНА-2023/25-3-ШТА-ГА кодтой) сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Э.Энхбат, аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Должмаа)-д даалгасугай.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 24-ний дотор ирүүлэхийг Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (У.Балжинням), Мал эмнэлгийн газрын дарга (Л.Оюун-Эрдэнэ), Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Батхуяг)-д зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Б.Должмаа), аудитор (Б.Нарангэрэл), аудитор (Н.Батчимэг) нарт үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (А.Цэням), ахлах аудитор (Б.Должмаа)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

005010060



АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ 3

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5

БҮЛЭГ А. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ОЛГООГҮЙ БАЙНА. 6

БҮЛЭГ Б. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙГ ОРОН НУТАГТ ШААРДЛАГАТАЙ, ҮР ӨГӨӨЖТЭЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН БАЙНА..... 6

Б.1.Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгөөр урт, дунд, богино хугацааны бодлого, чиглэлийг үндэслэн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан 4,033.7 сая төгрөгийн 3 төсөл хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна..... 6

Б.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь цаг үеэ олсон, үр нөлөөтэй байгаа хэдий ч орон нутагт хариуцан ажиллаж байгаа байгууллагууд үр дүнг тооцож ажиллаагүй байна. 13

БҮЛЭГ В. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЙД, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРӨӨР ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТУСГААГҮЙГЭЭС ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА. 18

В.1.Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд орон нутгийн байгууллагуудаас хяналт тавих чиг үүрэг байхгүй байна..... 18

В.2 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд журамд заасны дагуу жил бүр үнэлж, үр дүнг тооцсон байна. 20

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ 23

ДҮГНЭЛТ.....24

ЗӨВЛӨМЖ..... 25

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ..... 25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<i>ААН</i>	<i>Аж ахуйн нэгж</i>
<i>АДБОУБ</i>	<i>Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага</i>
<i>АДБОУС</i>	<i>Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт</i>
<i>АХБ</i>	<i>Азийн хөгжлийн банк</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын Тамгын газар</i>
<i>ИТХ</i>	<i>Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</i>
<i>МАОЭЗЭН</i>	<i>Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх</i>
<i>МЭЭГ</i>	<i>Мал эмнэлгийн Ерөнхий газар</i>
<i>ҮАГ</i>	<i>Үндэсний аудитын газар</i>
<i>ХААХҮ</i>	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр</i>
<i>ХХААГ</i>	<i>Хүнс, хөдөө, аж ахуйн газар</i>
<i>ХХААХҮЯ</i>	<i>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</i>



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээ	5
Хүснэгт 2	Баянхонгор аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	6
Хүснэгт 3	Айл өрх, хоршоонд олгосон хөрөнгийн жагсаалт	10
Хүснэгт 4	Хүнсний тусламж олгох малчин өрхийн тоо	12
Хүснэгт 5	Экспортыг дэмжих төслийн цахим системд байршуулсан мэдээлэл	13
Хүснэгт 6	“Баялаг-Өлзий” ХХК-ийн экспорт хөгжүүлэх төлөвлөгөө	16
Хүснэгт 7	Экспортыг дэмжих төслийн цахим системд байршуулсан мэдээлэл	19
Хүснэгт 8	Төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил	20
Хүснэгт 9	Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан 2020-2022 он	21
Хүснэгт 10	“Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл”-ийн хүрээнд бий болсон хөрөнгийн жагсаалт (сая.төг)	22

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”, А/04 дүгээр тушаалаар баталсан “Аудитын жилийн төлөвлөгөө батлах”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

ХХААХҮЯ, Сангийн яам, хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл, тусламжийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан гүйцэтгэлийн аудитын нэгдсэн төлөвлөгөө, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, холбогдох байгууллагуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Засгийн Газрын шугамаар авсан зээлийг үр дүнтэй ашиглаж байгаа эсэх;
- Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжтэй байгаа эсэх;
- Зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх

Аудитын хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн ЗДТГ, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, аймгийн Онцгой байдлын газар, сумдын ЗДТГ, тусламж авсан аж ахуйн нэгж, бусад холбогдох байгууллага, иргэний үйл ажиллагааг 2016-2022 оныг хамруулан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”



**Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлтүүд**

стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Гүйцэтгэлийн аудитад дараах хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин" (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам";
- Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам";
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

**Аудитын
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, аудитын менежер А.Цээням аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Нарангэрэл, Н.Батчимэг нар хамтран гүйцэтгэв.

Аудитын дэд төлөвлөгөө, хөтөлбөрийг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр батлуулж, талбарын ажлыг 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийн хугацаанд гүйцэтгэж, тайлагналын үе шатны ажлыг 8 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн гүйцэтгэж, тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар баталгаажуулан, тус өдөр УАГ-ын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймгийн ИТХ, Засаг дарга, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ мэдээллээр хангах Баянхонгор аймгийн орон тооны байнгын ажлын хэсэг, аймгийн ХХААГ, МЭГ-т хүргүүлэв.

Байхгүй.

**Хүндрэл
бэрхшээл**



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Өрийн удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг санхүүжүүлэх” гэсний дагуу хандивлагч орон, олон улсын байгууллагаас гадаад зээл авч байна.

ҮАГ-ын баталсан нэгдсэн төлөвлөгөөнд аудитад хамрагдах 28 төсөл арга хэмжээнээс Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын дэд төлөвлөгөөний хүснэгт 1-д нийт 9 төсөл арга хэмжээг хамруулахаар төлөвлөсөн боловч ҮАГ-аас 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр Microsoft teams-т байршуулсан чиглэлийн дагуу аудитын хамрах хүрээг 9 болгож өөрчилсөн ба үүнээс Баянхонгор аймагт хамааралтай дараах 3 төслийн арга хэмжээг аудитад хамруулж, бусад төсөл арга хэмжээ хамрагдаагүй болно.

Хүснэгт 1. Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээ (сая.төг)

№	Төслийн нэр	Хугацаа	Зорилго	Мөнгөн дүн
1	“Экспортыг дэмжих” төсөл (Дэлхийн банк)	2016-2023 он	Уул уурхайн бус салбарын жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх	32.2
2	“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл (Дэлхийн банк)	2020-2025 он	Мал сүргийн эрүүл мэнд, ашиг шим, нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай арга хэмжээ хэрэгжүүлэх	3,575.2
3	“Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл (Азийн хөгжлийн банк)	2021-2024 он	Агробизнесийн чиглэлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулах замаар хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн дэмжин ажлын байр бий болгох, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах	426.3
ДҮН				4,033.7

Эх сурвалж: ҮАГ-аас 2023.07.06-ны өдөр Microsoft teams-т байршуулсан чиглэл

Аудитад орон нутгийн байгууллагуудаас хийсэн хяналтын тайлан, мэдээ, мэдээлэл олдоогүй тул төсөл арга хэмжээний хяналт, үр дүнгийн талаар мэдээллийн Бүлэг В-г “Экспортыг дэмжих төсөл”-ийн www.edp.mn, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн www.lcp.mn, ХХААХҮЯ-ны www.mofa.gov.mn, Үндэсний аудитын газрын www.audit.mn, Шилэн дансны нэгдсэн цахим хуудас shilendans.gov.mn зэрэг вэб сайтууд, Үндэсний аудитын газрын Microsoft teams-т байршуулсан төсөл хөтөлбөрүүдийн тайлан, мэдээ, мэдээлэлд үндэслэн бэлтгэв.

**АУДИТЫН ДҮН**

БҮЛЭГ А. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШУГАМААР АВСАН ЗЭЭЛЭЭС БАЯНХОНГОР АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГАД ОЛГООГҮЙ БАЙНА.

БҮЛЭГ Б. ХАНДИВЛАГЧ ОРОН, ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС АВСАН ТУСЛАМЖИЙГ ОРОН НУТАГТ ШААРДЛАГАТАЙ, ҮР ӨГӨӨЖТЭЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН БАЙНА.

Б.1.Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгөөр урт, дунд, богино хугацааны бодлого, чиглэлийг үндэслэн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан 4,033.7 сая төгрөгийн 3 төсөл хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Б.1.1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт 4.2, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан " МУЗГ-ын 2020-2024-оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.5.2, МУЗГ-ын 2018 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Монгол экспорт хөтөлбөр"-ийн 4.1.3, 4.1.13, 4.2.2, 4.2.8, МУЗГ-ын 2018 оны 140 дүгээр тогтоолоор баталсан (тодотгол МУЗГ-ын 2019 оны 290) "Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгагдсан, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл "Тогтвортой хөдөө аж ахуй" зорилт 8.3 зэрэг заалтуудад нийцүүлэн Баянхонгор аймагт нийт 4,033.7 сая төгрөгийн дараах тусламжийг олгосон байна.

Хүснэгт 2.Баянхонгор аймгийн хэмжээнд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ (сая.төг)

№	Төсөл	Төсөл, арга хэмжээнд хамрагдсан ААН, иргэн	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүжилт
1	Экспортыг дэмжих төсөл	"Баялаг-Өлзий" ХХК	1.Экспорт хөгжүүлэх төлөвлөгөө	22.2
		"Их халбаганат" ХХК	2.Экспорт хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	10.0
2	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл	Баянхонгор аймгийн сумын малчин өрхүүд 20	3.Баянхонгор аймгийн 20 сумын 12,970 малчин өрхөд 3.1 тонн хүчит тэжээлийн тусламж үзүүлэх	3,568.4
		Галуут, Бөмбөгөр, Хүрээмарал, Бууцагаан сумдын 280 малчин	4."Түгээмэл тохиолдож байгаа малын халдварт өвчнүүд, тэдгээрийг өвөрмөц шинж тэмдэгт тулгуурлан эрт илрүүлж, мэдээлэх мэдлэг, дадал олгох" сургалтыг зохион байгуулах	2.8
		Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	5.Аймгийн Мал эмнэлгийн газрын хэрэгцээнд зориулж Rotenzo 55C510KC Android үйлдлийн системтэй 55" TV (зөөврийн хөлийн хамт), Tenveo TEVO-VHD102U видео хурлын камер, Tenveo TEVO-NA100B видео хурлын чанга яригчтай микрофон тус тус нийлүүлэх	4.0
		Баацагаан сумын 5, Өлзийт сумын 15, Эрдэнэцогт сумын 5, нийт 25 өрх, "Сүүн билэгдэл", "Наян булаг тал" хоршоо	6.Сүүний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг хоршоо, иргэдэд иж бүрдэл, тоног төхөөрөмж олгох	66.4




3	Хөдөө аж ахуйн хөдөөгийн төслийн нэмэлт санхүүжилт	Баацагаан, Өлзийт, Эрдэнэцогт, Галуут сумын малчид, ХХААГ-ын холбогдох мэргэжилтэн	7.Төслийн танилцуулга, нэмүү өртгийн сүлжээний үндсэн ойлголт, хамрагдах салбаруудын боломж, тулгарч буй асуудлууд, бизнес, санхүүгийн шинжилгээ, үнэлгээ, арилжааны банкнуудын хийдэг үнэлгээнээс ялгарах зүйлүүд, нийгэм байгаль орчны хамгааллын үнэлгээ, тавигдах шаардлагыг хангуулах, АХБ болон МУЗГ-ын хууль, тогтоомжийн ялгаа болон ижил зүйлүүдийг танилцуулах сургалтыг зохион байгуулах	9.3
		Баянговь, Баацагаан, Бууцагаан, Богд сумдын өрхүүд	9.Баянхонгор аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усан геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх	24.0
		Бууцагаан, Шинэжинст, Жинст, Баацагаан, Баянговь сумын малчин өрхүүд	10.Баянхонгор аймгийн бэлчээрт инженерийн хийцтэй 5 худаг шинээр барьж байгуулах	124.6
		Баянхонгор сумын 2500 малчин өрх	11.Өвөлжилт хүндэрсэн аймгуудын малчдад хүнсний тусламжийн бараа нийлүүлэх	202.0
ДҮН				4,033.7

Эх сурвалж: УАГ-аас Microsoft teams-т байршуулсан мэдээ, мэдээлэл

Б.1.2. Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр олон нийтэд чиглэсэн, шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

“Экспортыг дэмжих төсөл”

Тус төслөөс санхүүгийн дэмжлэг авсан “Баялаг-Өлзий” ХХК нь 1991 оноос эхлэн малын түүхий эдийг бэлтгэн нийлүүлэх зарчмаар үйл ажиллагаагаа эхлүүлж, 2008 оноос сарлагийн хөөвөр, ноос, ноолуурыг эцсийн бүтээгдэхүүн болгон гадаад, дотоодын зах зээлд нийлүүлэх, анхан шатны түүхий эд боловсруулах болон



сүлжмэл эдлэлийн гэсэн хоёр төрлийн үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компанийн албан ёсны хаяг нь Баянхонгор аймгийн Баянговь сумын 5 дугаар багт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны товчооны зам 23-1 хаяг дахь “Бодиос” үйлдвэрт компани үндсэн үйл ажиллагааг явуулж байна.



Малын гарал угсаа нь тодорхой түүхий эдийг эцсийн бэлэн бүтээгдэхүүн болгон борлуулалтын 76 хувийг Оросын Холбооны Улс, Англи, Америк, Япон, Солонгос болон Европын нэгдсэн улсуудад экспортолсон байна. Энэ нь “Экспортыг дэмжих төсөл”-ийн санхүүгийн дэмжлэгийн хүрээнд тавьсан зорилтыг хангаж, экспортын бүтээгдэхүүний нэр төрөл олширч, гаргах гадаад зах зээлийн тоо өргөжиж, экспортын борлуулалтын орлого нэмэгдүүлэх зэрэг Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ахиц бий болохоор байна.

“Их халбаганат” ХХК нь 2002 оноос төрөл бүрийн барааны дэлгүүр, фото зураг, компьютерын үйлчилгээг Баянхонгор аймгийн Баянлиг суманд явуулж эхлэн, 2004 оноос талх нарийн боов, 2009 оноос сүүний цехээ нээн өргөжүүлсэн байна. Тус ААН



нь ингэний сүүтэй ааруул, дарс, шимийн архи, ундаа, молоко, тараг, хатаасан аарц, бялуу, боорцог зэрэг нийт 23 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, Баянхонгор, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг газруудад ингэний хоормог, сүү, аарцаа борлуулдаг байна.

“Их халбаганат” ХХК нь “Экспортыг дэмжих төсөл”-өөс 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг аваагүй гэсэн 10 дугаар албан бичгийг 2023.06.06-ны өдөр ирүүлсэн тул энэ талаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар 1/380 дугаар албан бичгээр УАГ-т явуулсан боловч хариу ирүүлээгүй.

Иймд аудитын баг 2023 оны 08 дугаар сарын 11-ний өдөр төсөл хэрэгжүүлэгч нэгжид албан захидал бичсэнээр тус ААН нь 10.0 сая төгрөгийн дэмжлэг авснаа хүлээн зөвшөөрсөн боловч холбогдох баримт материалыг аудитын хугацаанд бүрэн ирүүлээгүй тул ААН-ийн баримт материалыг төсөл хэрэгжүүлэгч нэгжээс 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр авч шалгасан.

Монгол нүүдэлчдийн онц гайхалтай ундааны нэгэн зүйл болох ингэний сүү, ингэний сүүний орц найрлага бүхий бүтээгдэхүүнийг Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Өвөр Монголын Өөртөө Засах Орны томоохон хот, аймгуудад экспортлох гарц гаргалгааг бодит судалгаа шинжилгээнд үндэслэн тооцоолох зорилготой “Экспортын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” 20.0 сая төгрөгийг төслийг “Экспортыг дэмжих төсөл”-д өгсөн нь дэмжигдсэн байна. Төслийн санхүүжилтийн 50 хувь буюу 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг тус төслөөс авч, үлдэх 10.0 сая төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн, “Экспортын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг “Эрч нэмэх” ХХК-тай 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдөр 02 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

“Их халбаганат” ХХК нь “Эрч нэмэх” ХХК-ийн боловсруулсан төслийн дагуу ингэний сүү, ингэний сүүний орц найрлага бүхий бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд нийлүүлж эхлэх эхний алхам тавигдсан байна.



“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл

1. МУЗГ-аас 2020-2021 оны өвөлжилт хүндрэх нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 213 дугаар тогтоолоор Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” (цаашид МААЭЗЭН гэх) төслийн бүрэлдэхүүн 4 буюу “Болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсэг”-ийг идэвхжүүлсэн байна. Уг тогтоолд өвөлжилт хүндэрч болзошгүй аймаг, сумдын гамшгийн эрсдэлийг үнэлсэн бөгөөд Баянхонгор аймгийн болон бусад аймагт отроор явж байгаа болон бүх малчдад зохих журмын дагуу дэмжлэг үзүүлэхээр тогтоосон байна. Баянхонгор аймгийн хэмжээнд 20 сумдын малчдад 3,568.4 сая төгрөгийн нийт 3,112,800 кг хүчит тэжээлийг тараасан байна. Дээрх малын тэжээлийн тусламж нь Баянхонгор аймгийн хэмжээнд малын хорогдлыг бууруулахад ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

2. МААЭЗЭН төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн “Малын эрүүл мэндийн үйлчилгээ” хэсгийн хүрээнд “Эрт илрүүлэх, хариу арга хэмжээ болон оролцоот эпидемиологийн тандалт” сургалтыг Баянхонгор аймгийн Галуут, Бөмбөгөр, Хүрээмарал, Бууцагаан сумдын 280 малчдыг хамруулан зохион байгуулжээ. Сургалтаар малчдыг тухайн нутгийн мал сүрэгт түгээмэл тохиолдож байгаа болон бусад нутгаас дамжин халдварлаж болзошгүй халдварт өвчнүүдийн талаар суурь ойлголттой болгох, улмаар халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлэн мал эмнэлгийн байгууллагад шуурхай мэдээлдэг болгох, малын халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед малын эмч ирэх хүртэл өөрийгөө болон гэр бүлийн гишүүдээ хамгаалахын тулд юу хийх, сүргийн бусад малд халдвар дамжихаас хамгаалахын тулд юу хийх, айл хөрш байгаа малчдад ямар мэдээлэл хүргэх талаарх мэдлэг, чадварыг малчдад олгосон байна.

3. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн бүрэлдэхүүн хэсэг 1.2 Малын өвчний тандалт ба хяналт, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах ажлын хүрээнд Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын хэрэгцээнд зориулж Rotenzo 55C510KC Android үйлдлийн системтэй 55" TV (зөөврийн хөлийн хамт), Tenveo TEVO-VHD102U Видео хурлын камер, Tenveo TEVO-NA100B Видео хурлын системийн чанга яригчтай микрофон зэрэг 4.0 сая төгрөгийн хөрөнгийг нийлүүлснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4¹-д заасны дагуу 202 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгууллагын хөрөнгөд бүртгэсэн байна.

Дүрслэл №3 Баянхонгор аймгийн МЭГ-т бүртгэсэн хөрөнгүүд



¹ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ



“Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл

1. МУЗГ, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан гэрээ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, аймгийн Засаг даргын 2019 оны хамтран ажиллах гэрээнд тусгасан “Мах, сүүний анхдугаар аян”-ыг нутаг дэвсгэртээ өөрийн онцлогт тулгуурлан зохион байгуулах арга хэмжээн дэх “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл”-өөс 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдөр сүүний чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг Баянхонгор аймгийн Баацагаан сумын 5,



Өлзийт сумын 15, Эрдэнэцогт сумын 5, нийт 25 өрх тус бүрд 9 нэр төрлийн 1.7 сая төгрөгийн үнэ бүхий нийт 42.7 сая төгрөгийн 300 ширхэг тоног төхөөрөмж, Эрдэнэцогт сумын “Сүүн билэгдэл”, Өлзийт сумын “Наян булаг тал” хоршоонд тус бүр нь 11.8 сая төгрөгийн үнэ бүхий 10 нэр төрлийн, нийт 52 ширхэг 23.7 сая төгрөгийн иж бүрдэл, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй олгосон байна.

Хүснэгт 3. Айл өрх, хоршоонд олгосон хөрөнгийн жагсаалт (мян.төг)

№	Малчид хоршоонд зориулсан иж бүрдэл багаж	Нэгжид өгөх тоо	Нийт тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Өрхөд олгосон хөрөнгийн жагсаалт					
1	Зэвэрдэггүй гангаар хийсэн дан ханатай, таг, түгжээтэй сүү, аарц хадгалах 100 литр багтаамжтай торх	1	25	402.0	10,050.0
2	Сүүний цөцгийн ялгагч сепаратор /гар ажиллагаатай/	1	25	306.4	7,659.8
3	40 литр багтаамжтай сүүний бидон	1	25	270.6	6,764.7
4	20 литр багтаамжтай сүүний бидон	1	25	164.3	4,107.1
5	Сүүний нийтлэг шүүлтүүр	2	50	8.7	435.2
6	Сүүний хөнгөн цагаан шүүлтүүр	1	25	39.4	985.0
7	Аарц, бяслаг шахагч багаж	1	25	218.8	5,471.2
8	Зэвэрдэггүй ган буюу хөнгөн цагаан хүрээтэй 60*90 см хэмжээтэй ааруулын дэлгэц, тавиур	3	75	89.5	6,16.2
9	Саалийн хувин 5 литр багтаамжтай	1	25	21.9	548.2
	Өрхөд олгосон дүн	12	300		42,737.5
Хоршоонд олгосон хөрөнгийн жагсаалт					
1	Гар болон цахилгаанаар ажилладаг сүүний цөцгий ялгагч сепаратор /цагт 220 литр сүү ялгах/	1	2	3,720.4	7,440.8
2	Зэвэрдэггүй гангаар хийсэн дан 200 литр багтаамжтай ханатай, таг, түгжээтэй сүү, аарц хадгалах торх	1	2	660.0	1,320.0
3	Сүүний нийтлэг шүүлтүүр	5	10	8.7	87.0
4	Сүүний хөнгөн цагаан шүүлтүүр	2	4	39.4	157.6
5	Бяслаг, аарц шахагч шахуурга /гар ажиллагаатай/	2	4	218.8	875.4
6	Зэвэрдэггүй ган буюу хөнгөн цагаан хүрээтэй 60*90 см хэмжээтэй ааруулын дэлгэц	9	18	89.5	1,611.9
7	Пергамент цаас /50 кг рулон-боодлоор/	2	4	653.3	2,613.3
8	Аарц, бяслаг зүсэгч /гар ажиллагаатай/	1	2	461.8	923.6
9	Масло цохигч /60 литр багтаамжтай/	1	2	3,782.0	7,564.0
10	Сүүний бидон 40 литр багтаамжтай	2	4	270.6	1,082.4
	Хоршоонд олгосон дүн	26	52		23,676.0
	ДҮН	38	352		66,413.5

Эх сурвалж: Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн тоног төхөөрөмж нийлүүлэгч “Агротрейд импекс” ХХК-ийн баримт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжээс сонгогдсон Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын 5 багийн хамгийн олон хүүхэд 5 малчин өрх, Өлзийт сумын Түйн гол дагуу нутагладаг олон сарлагтай, сүүний чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломжтой 2 багийн 10



өрх, Шаргалжуут тосгоны 5 өрх, Баацагаан сумын хөдөөгийн 2 багийн 5 малчин өрхөд нийт 42.7 сая төгрөгийн сүү боловсруулах тоног төхөөрөмжийг буцалтгүй тусламжаар олгожээ.

2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл”-өөс Улаанбаатар хотод 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Баянхонгор, Өлзийт, Баянцагаан, Богд, Гурванбулаг, Шинэжинст, Заг, Эрдэнэцогт зэрэг 8 сумын 74 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, малчныг “Мал, мах, арьс ширэн түүхий эд бэлтгэл, анхан шатны боловсруулалт” сэдэвт технологийн сургалтад хамруулан, арьс шир боловсруулах 2 үйлдвэрт туршлага судлуулж, тус төслөөс сургалтад оролцогчдод томилолт, унаа, хоолны зардалд нийт 7.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг олгосон байна.



3. Мөн тус төслийн санхүүжилтийн 2.1 сая төгрөгөөр төслийн танилцуулга, нэмүү өртгийн сүлжээний үндсэн ойлголт, хамрагдах салбаруудын боломж, тулгарч буй асуудлууд, бизнес, санхүүгийн шинжилгээ, үнэлгээ, арилжааны банкнуудын хийдэг үнэлгээнээс ялгарах зүйлүүд, нийгэм байгаль орчны хамгааллын үнэлгээ, тавигдах шаардлагыг хангуулах, АХБ болон МУЗГ-ын хууль, тогтоомжийн ялгаа болон ижил зүйлүүдийн талаарх сургалтыг зохион байгуулсан гэсэн мэдээллийг УАГ-аас Microsoft teams-т байршуулсны дагуу аймгийн ХХААГ-ын холбогдох мэргэжилтнээс тодруулахад “Улаанбаатар хотод төслийн нэгж өөрөө зохион байгуулж, сургалтад малчид хамрагдсан, хэдэн хүн хамрагдсаныг мэдэхгүй байна, Баянхонгор аймгийн ХХААГ зохион байгуулах үйл ажиллагаанд нь оролцсон, сургалтын хөтөлбөр, тайлан байхгүй” гэсэн тайлбарыг өгсөн тул тус арга хэмжээг орон нутагт үзэх боломжгүй байна.

Иймд аймгийн мэргэжлийн байгууллага нь төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, цаашдын үр дүн, үр нөлөөг сайжруулах тал дээр хамтарч ажиллаж байх шаардлагатай байна.


4. Баянхонгор аймгийн бэлчээрт уст цэг тогтоох газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэх ажлын хүрээнд Баянговь, Баацагаан, Бууцагаан, Богд сумдад 21 бэлчээрт хайгуул хийж уст цэг тогтоох арга хэмжээнд 24.0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан гэх мэдээллийг УАГ-аас ирүүлсний дагуу аймгийн ХХААГ-ын холбогдох мэргэжилтнээс тодруулахад манай байгууллагын 2019-2021 оны үйл ажиллагааны тайланд уст цэг тогтоосон талаар тусгагдаагүй, уст цэгийн судалгаанд байхгүй гэх тайлбар өгсөн тул тус арга хэмжээг орон нутагт үзэх боломжгүй байна.



5. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл"-өөр Баянхонгор аймгийн Бууцагаан, Шинэжинст, Жинст, Баацагаан, Баянговь сумдад 2020, 2021 онд инженерийн хийцтэй 124.6 сая төгрөгийн өртөг бүхий 5 ширхэг худгийг гаргаж, ашиглалтад оруулснаар говийн 5 сумын 5 багийн малчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн байна.



6. Төслийн хүрээнд ХХААХҮЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2021 оны А/48 дугаар тушаалыг үндэслэн 2021 онд Баянхонгор аймгийн 20 сумын 2,500 малчин өрхөд 202.0 сая төгрөгийн 66,875 кг (нэг өрхөд олгосон багц бараа: улаан буудайн 1 дүгээр гурил 10 кг, ургамлын тос 4.7 литр, элсэн чихэр 3 кг, цайны идээ 0.7 кг, цагаан будаа 8кг) хүнсний яаралтай тусламжийн барааг олгохоор шийдвэрлэсэн байна.



Тус ажлыг зохион байгуулах шуурхай бүлгийг Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн “Малчин өрхөд хүнсний тусламж олгох ажлыг зохион байгуулах шуурхай бүлэг томилох тухай” А/179 дүгээр захирамжаар томилж, тусламжид хамрагдах сумдын малчин өрхийг захирамжийн 2 дугаар хавсралтаар баталж, шуурхай бүлэг сумдад олгосон байна.

Хүснэгт 4. Хүнсний тусламж олгох малчин өрхийн тоо

№	Сумын нэр	Малчин өрхийн тоо	№	Сумын нэр	Малчин өрхийн тоо
1	Баянхонгор	115	11	Бууцагаан	170
2	Баацагаан	175	12	Галуут	180
3	Баянлиг	140	13	Гурванбулаг	70
4	Баянговь	120	14	Жаргалант	170
5	Баянбулаг	70	15	Жинст	100
6	Баян-Овоо	100	16	Заг	80
7	Баян-Өндөр	80	17	Өлзийт	170
8	Баянцагаан	120	18	Хүрээмарал	70
9	Богд	140	19	Шинэжинст	80
10	Бөмбөгөр	170	20	Эрдэнэцогт	160
		ДҮН			2,500

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.03.11-ний өдрийн А/179 дүгээр захирамж

Б.1.3. Баянхонгор аймгийн хэмжээнд хэрэгцээ, шаардлагад нийцсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд эдгээр тусламжийн хөрөнгийг сонгох, үнэлэх,



эрэмбэлэх ажлыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлээгүй тул аудитаар үзэх боломжгүй байсан.

“Экспортыг дэмжих” төсөл

ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжиж буй Экспортыг дэмжих төслийн хүрээнд байгуулсан “Түншлэлийн хөтөлбөрийн хүрээнд аж ахуйн нэгж байгууллагуудад дэмжлэг олгохтой холбоотойгоор “Түншлэлийн хөтөлбөр хэрэгжүүлэх заавар” гэсэн баримт бичгийг боловсруулсан. Тус баримт бичгийн дагуу 2022 онд нийт 203 төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүсэлтийг хүлээн авч холбогдох судалгаа шинжилгээ болон сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж ажиллан, шаардлага хангасан 48 ААН-ийн материал дэмжигдэж 9,980.7 сая төгрөгийн дүн бүхий түншлэлийн гэрээг байгуулсан талаар төсөл хэрэгжүүлэгч нэгжийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсан байна.

Шалгарсан 48 аж ахуйн нэгжээс Баянхонгор аймгийн хэмжээнд Баянговь сумын “Баялаг-Өлзий” ХХК, Баянлиг сумын “Их халбагант” ХХК, Баянхонгор сумын “Урт наст эх” ХХК -ийн төслүүд шалгарч, “Урт наст эх” ХХК-д одоогоор санхүүгийн дэмжлэгийг олгоогүй тул аудитад хамрагдаагүй болно.

Хүснэгт 5. Экспортыг дэмжих төслийн цахим системд байршуулсан мэдээлэл (сая. төг)

ААНБ-ын нэр	Түншлэлийн гэрээний дүн	Олгосон санхүүгийн дэмжлэг	Олгосон санхүүжилтийн хувь
“Баялаг Өлзий” ХХК	69.7	22.2	40%
“Их халбагант” ХХК	10.0	10.0	100%
“Урт наст эх” ХХК	48.6	0	0%
ДҮН	128.3	32.2	46.6%

Эх сурвалж: Экспортыг дэмжих төслийн албан ёсны вэб сайт www.edp.mn

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл

МУЗГ-ын 2020 оны “Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 213 дугаар тогтоолд заасны дагуу өвөлжилт хүндэрч болзошгүй аймаг сумдын гамшгийн эрсдэлийг үнэлэхэд Баянхонгор аймаг нь гамшгийн эрсдэлээр “хүнд” гэж үнэлэгдсэн тул аймгийн болон отроор явж буй бүх сумдын малчдад хүчит тэжээлийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн байна.

“Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд Баянхонгор аймгийн хэмжээнд 426.3 сая төгрөгийн хөрөнгөөр малчдад сургалт зохион байгуулах, тоног төхөөрөмж нийлүүлэх, хүнсний дэмжлэг үзүүлэх, уст цэг тогтоож, худаг гаргах зэрэг нь арга хэмжээг хэрэгжүүлсэн нь олон нийт, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Б.2. Тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь цаг үеэ олсон, үр нөлөөтэй байгаа хэдий ч орон нутагт хариуцан ажиллаж байгаа байгууллагууд үр дүнг тооцож ажиллаагүй байна.

Б.2.1.Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжсэн малчдад зориулсан сургалтыг удирдамжийн дагуу зохион байгуулаагүй байна.



“Экспортыг дэмжих” төсөл

Уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх, КОВИД-19 цар тахлын үр нөлөөг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн бүрэлдэхүүн 2.3 буюу Түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан “Баялаг-Өлзий” ХХК-ийн “Ноолууран эдлэл, бэлэн хувцас үйлдвэрлэл”-ийн болон “Их халбаганат” ХХК-ийн “Экспортын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” төсөл нь МУЗГ-ын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын 4.1² буюу төсөл арга хэмжээнд тавих шаардлагыг хангасан байна.

“Баялаг-Өлзий” ХХК нь “Экспорт хөгжүүлэх төлөвлөгөө”-нд заасан арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулан ажилласан байна. Тухайлбал:

“Урбан номадс” ХХК-тай Eshgen брэндийн загвар дизайныг гаргах, лого зохиох ажлыг 2022.01.11-2022.03.30-ны өдөр, “Оргил медиа менежмент” ХХК-тай Бодиос брэндийн сурталчилгааны видео, зураг авалт хийх ажлыг 2021.12.01-2021.12.30-ний өдөр хийж гүйцэтгүүлэхээр тус тус гэрээ байгуулан төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажилласан байна.

“Их халбаганат” ХХК нь ХХААХҮЯ, Экспортыг дэмжих төсөлтэй 2022.01.25-ны өдөр ТХ/03/11 дугаартай түншлэлийн гэрээг байгуулан “Экспортын хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” төслийн санхүүжилт 50 хувь буюу 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг авсан, түншлэлийн гэрээний үйл ажиллагааны төлөвлөгөөнд ажлыг 2022 оны 01 дүгээр сард эхэлж, гэрээ дуусах хугацааг 2022 оны 02 дугаар сард төлөвлөсөн байна. Гэвч тус компани нь ажил гүйцэтгэгч ААН-ийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2022.02.21-ны өдөр байгуулж, сонгон шалгаруулалтыг 2022.03.11-ний өдөр зохион байгуулж, шалгарсан “Эрч нэмэх” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2022.03.15-2022.10.15-ны өдөр хүртэл 7 сарын хугацаатай байгуулж, 3 удаагийн шилжүүлгээр төлбөрийг бүрэн шилжүүлсэн байна.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл

МУЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 213 дугаар тогтоолын дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/21 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэг “Малчин өрхөд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах түр журам”-ын дагуу нийт 20 сумдын 12970 өрхөд, нэг өрхөд

²4.1.1. Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцсэн байх;

4.1.2. Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан байх;

4.1.3. Засгийн газрын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх болон хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээтэй уялдсан байх.

4.2. Олон улсын байгууллага, түншлэгч оронтой байгуулах гэрээ, хэлэлцээр нь Монгол Улсын нийтлэг ашиг сонирхолд нийцсэн байна.

4.3. Төслийн онцлогийг харгалзан техник, эдийн засгийн үзүүлэлт, нийгэм болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тооцсон байна.



0.3 сая төгрөгийн өртөг бүхий 240 кг хүчит тэжээл буюу нийт 2,882,640 кг өвсийг тараасан байна. Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 16/248 дугаар албан бичгээр Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн нэгжид нэмэлтээр 240,220 кг хүчит тэжээлийн тусламжийг хүссэний дагуу нийт Баянхонгор аймгийн хэмжээнд 3,112,810 кг өвс тэжээлийг үйлдвэрлэгч 4 аж ахуйн нэгж байгууллагаар дамжуулан хүлээн авч сумдад хугацаанд нь тараасан байна.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-өөс зохион байгуулсан цахим сургалтад хамрагдсан Баянхонгор аймгийн Галуут сумын малын эмч Г.Батбаяр Галуут, Хүрээмарал, Бөмбөгөр, Бууцагаан сумдаас тус бүр 70, нийт 280 малчдад “Түгээмэл тохиолдож байгаа малын халдварт өвчнүүд, тэдгээрийг өвөрмөц шинж тэмдэгт тулгуурлан эрт илрүүлж, мэдээлэх мэдлэг, дадал олгох” сургалтыг зохион байгуулахад төслөөс 2.8 сая төгрөгийг олгосон байна.

Малын эрүүл мэнд, үр ашиг, бүтээмж болон төсөл хэрэгжих газрууд дахь нэмүү өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгын хүрээнд зохион байгуулсан тус сургалтаар төслөөс “Малчдад зориулсан гарын авлага”-ыг нийт 350 ширхгийг олгосноос малчдад 1.4 сая төгрөгийн 280 ширхэг гарын авлагыг тарааж, аймгийн Мал эмнэлгийн газарт 70 ширхэг гарын авлагыг олгожээ.



Аудитын илрүүлэлт

• МAAЭЗЭН төслөөс ирүүлсэн “Малчдад зориулсан малын эрүүл мэндийн сургалт зохион байгуулах байршил, оролцогч болон хамрах хүрээ” гэсэн баримт бичигт Баянхонгор аймагт зохион байгуулах сургалтын хугацааг 2022.10.15-2022.10.30-ны хооронд хийхээр тодорхойлсон байхад гэрээт ажлын тайлан хүлээн авсан актад гэрээний хугацааг 2022.12.07-2022.12.25-ны хооронд гэж тодорхойлсон нь зөрүүтэй байгаа бөгөөд Бууцагаан, Хүрээмарал, Бөмбөгөр сумдад 2023 оны 1 дүгээр сард, Галуут суманд 2 дугаар сард сургалтыг зохион байгуулсан нь төслөөс заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

• Тус сургалтыг Галуут сумын малын эмч Г.Батбаяр хийж, орон нутагт сургалт зохион байгуулагчийн зардлын 1.3 сая төгрөгийг түүний дансаар олгосон байхад тухайн эмч зөвхөн Галуут суманд сургалтыг хийж, бусад 3 суманд аймгийн Мал эмнэлгийн газрын ариун цэвэр магадлан шинжилгээний шинжээч эмч Ч.Дашням хийж, түүнд Г.Батбаяраас 0.2 сая төгрөгийг өгсөн байна.

• МAAЭЗЭН төслөөс гаргасан “Малчдад зориулсан малын эрүүл мэндийн сургалтын удирдамж”-д “Нэг суманд 70-аас доошгүй малчны сургалтад хамруулсан байх ба тэдгээрийн 40-өөс доошгүй хувь нь эмэгтэй оролцогч байна” гэснийг мөрдөж ажиллаагүй, Хүрээмарал суманд зохион байгуулсан сургалтад хамрагдсан малчдын 31.4%, Галуут сумын малчдын 15.7 хувийг эмэгтэй малчид эзэлсэн байна.

Иймд цаашид төсөл, хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэв.

Б.2.2. Төсөл хэрэгжүүлэгч нэгжүүд төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тогтсон цаг хугацаанд хяналт тавьж байгаа боловч 2020 онд ХХААХҮЯ-аас хийсэн хяналт шинжилгээ-үнэлгээгээр төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдэд “Төслүүдээс гарах үр дүн, үр нөлөөг аймаг бүрээр гаргах, үнэлэх, зорилтот арга хэмжээ тус бүрээр хөрөнгийн зарцуулалтыг гаргахдаа төсөл болон оролцогчийн оролцоог мөнгөн дүнгээр илэрхийлэн арга хэмжээ тус бүрээр, тухайн оны ажлын төлөвлөгөөний биелэлтийг заалт тус бүрээр гаргаж тайлагнах” гэсэн зөвлөмж өгсөн байна. Гэвч тус зөвлөмжийг



бүрэн хэрэгжүүлээгүйгээс аудитаар орон нутагт хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт, гарсан үр дүнг тооцсон мэдээ, мэдээлэл байхгүй байна.

“Экспортыг дэмжих” төсөл

“Их халбаганат” ХХК нь гэрээний дагуу ажлын төлбөрийн 20.0 сая төгрөгийг “Эрт нэмэх” ХХК-д бүрэн шилжүүлэн, №02 дугаартай экспортын төлөвлөгөө хийх гэрээний хэрэгжилтийг компаниудын захирлууд 2022.10.05-ны өдөр дүгнэж, гэрээ дүгнэсэн актыг үйлдэж, гэрээний хэрэгжилтийг хангасан гэж дүгнэн дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Монгол нүүдэлчдийн онц гайхалтай ундааны нэгэн зүйл болох ингэний сүү, ингэний сүүний орц найрлага бүтээгдэхүүнийг хилийн чанд руу экспортлох гарц гаргалгааг бодит судалгаа шинжилгээнд үндэслэн тооцоолохоор зорьж ажилласан.
2. Зах зээлийн судалгаа болон, сав баглаа боодлын шинэчлэлт зэргийг гаргаж ирсэн.

Экспортыг дэмжих төслийн түншлэлийн хөтөлбөрт хамрагдсан “Баялаг-Өлзий” ХХК нь 69.7 сая төгрөгийн төсөвтэй “Ноолууран эдлэл, бэлэн хувцас үйлдвэрлэл”-ийн чиглэлээр санхүүгийн дэмжлэг хүссэн бөгөөд үүнээс 2022 оны 08 дугаар сарын 12-ны байдлаар 22.2 сая төгрөг буюу 40 хувийн санхүүгийн дэмжлэг хүлээн авсан байна.

Тус компани нь ХХААХҮЯ, экспортыг дэмжих төслийн нэгжтэй байгуулсан 2021.12.11-ны өдрийн ТХ/02/01 дугаартай түншлэлийн гэрээний хавсралт 1-д зааснаар 26.9 сая төгрөгөөр загварын болон бүтээгдэхүүний зураг авалт, 15.9 сая төгрөгөөр онлайн худалдаа болон бүтээгдэхүүний танилцуулга веб сайт танилцуулах, 11.9 сая төгрөгөөр eshgen брэнд гаргах (брэнд бүүк гаргах), 15.0 сая төгрөгөөр маркетинг болон үйл ажиллагаанд ашиглах видео болон фото контент гаргахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 6. “Баялаг-Өлзий” ХХК-ийн экспорт хөгжүүлэх төлөвлөгөө (сая.төг)

№	Зөвшөөрөгдсөн ажлууд	Төлөвлөгөө			Гүйцэтгэл		Мөнгөн дүн
		Эхлэх огноо	Дуусах огноо	Баталсан зардлын дээд хэмжээ	Гэрээ байгуулсан ААНБ	Гэрээ байгуулсан огноо	
1	Зураг авалт (загварын болон бүтээгдэхүүний)	11/23/2021	7/30/2022	26.9	“Оргил медиа менежмент” ХХК	12/1/2021	34.0
2	Онлайн худалдаа болон бүтээгдэхүүний танилцуулга веб сайт шинэчлэх (худалдан авалт хийх боломжтой болгох)	12/15/2021	7/30/2022	15.9			
3	Брэндбүүк гаргах (Eshgen брэнд)	12/1/2021	7/30/2022	11.9	“Урбан номадс” ХХК	1/11/2022	15.4
4	Маркетинг үйл ажиллагаанд ашиглах видео болон фото контент	11/23/2021	4/15/2022	15.0	“Оргил медиа менежмент” ХХК	12/1/2021	
	ДҮН			69.7			49.4

Эх сурвалж: ХХААХҮЯ, экспортыг дэмжих төслийн нэгжтэй байгуулсан 2021.12.11-ны өдрийн ТХ/02/01 дугаартай түншлэлийн гэрээ

Төлөвлөгөөний хэрэгжилтийг нотлох баримтаар тулган баталгаажуулахад “Урбан номадс” ХХК-тай 15.4 сая төгрөгийн гэрээ байгуулан “eshgen брэнд” гаргах (брэнд бүүк гаргах) ажлыг хийж гүйцэтгүүлсэн, “Оргил медиа менежмент” ХХК-тай гэрээ байгуулан 34.0 сая төгрөгийн маркетинг болон үйл ажиллагаанд ашиглах видео болон фото контентыг хийж гүйцэтгүүлсэн байгаа нь “Баялаг-Өлзий” ХХК-ийн экспортын үйл ажиллагааг дэмжиж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх давуу талтай байна.



“Хөдөө аж ахуйн хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төсөл

ХХААХҮЯ, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтийн төсөл”-өөс 2019 онд Баянхонгор аймгийн зорилтот 3 сумын 25 малчин өрх болон Өлзийт, Эрдэнэцогт сумын 2 хоршоонд 66.4 сая төгрөгийн сүү боловсруулах тоног төхөөрөмжийг олгож, тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулсан, эдгээр тоног төхөөрөмжийг олгосноор 2 хоршооны хувьд 17 тонн сүү боловсруулан 37.8 сая төгрөгийн ашигтай ажилласан гэж аймгийн ХХААГ-ын 2019 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланд дурдсан байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.03.11-ний өдрийн “Малчин өрхөд хүнсний тусламж олгох ажлыг зохион байгуулах шуурхай бүлэг томилох тухай” А/179 дүгээр захирамжаар томилж, ажлыг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг 2021.03.25-ны дотор ХХААХҮЯ-д тайлагнахыг шуурхай бүлэг (ХХААГ-ын дарга)-ийн даргад үүрэг болгосон байхад ХХААГ-аас энэ талаарх мэдээллийг гаргаж ирүүлээгүй болно.

Иймд ХХААХҮЯ, бусад төсөл хэрэгжүүлэгч нэгжээс аймагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж байх зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл

Тус төслөөс Баянхонгор аймгийн 4 сумын 280 малчдад зохион байгуулсан сургалтыг явуулснаар малчдад малд илрэх шинж тэмдгийн талаар мэдлэг олгох, малчны зүгээс авах арга хэмжээний талаарх зөвлөмжийг өгөх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар талбайн сургалтыг явуулсан ба сургалтыг үр дүнг

- Сургалтад хамрагдсан малчид өөрийн мал сүргийг халдвараас хамгаалах мэдлэг, дадалтай болсноос гадна халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг эрт илрүүлж, эмнэлгийн байгууллагад шуурхай мэдээлэх чадвартай болсон;

- Малчид мал эмнэлгийн үйлчилгээний ач холбогдлыг бүрэн ойлгож, мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээнд малаа бүрэн хамруулах үүрэг хариуцлагаа мэдэж авсан;

- Малын эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талууд болох малчид, сум, багийн удирдлагууд, МАА-н салбарт бизнес эрхлэгчид нь малын халдварт өвчнөөс учрах хор хохирлын талаар суурь мэдлэгтэй болсноор мал эмнэлгийн байгууллагатай хамтран ажиллах хандлагад эерэг өөрчлөлт гарсан гэж тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт

- МААЭЗЭН төслөөс ирүүлсэн “Малчдад зориулсан малын эрүүл мэнд, мал аж ахуйн өгөөж болон бүтээмжит түншлэлийн сургалтын тайлан” 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр бичсэн огноотой ба сургалт эхлээгүй байхад тайланг бичсэн байгаа бөгөөд малын эмч Г.Батбаяраас энэ тайлангийн талаар тодруулахад ийм тайлан бичээгүй, гарын үсэг зураагүй гэсэн тайлбарыг өгсөн нь МААЭЗЭН төслийн баримт материал үнэн зөв гэж үзэхээргүй байна.

- Галуут сумын малын эмч Г.Батбаяр аудитын явцад ирүүлсэн 2023.02.17-ны өдөр бичсэн 2 хуудас сургалтын тайланд сургалтын үр дүнгийн талаар бичээгүй байгаа ба, сургалт хийсэн 2 малын эмч сургалтын үр дүнг тодорхойлж, сургалтын үр дүнг тайлагнаагүй байна.

Иймд аймгийн Мал эмнэлгийн газарт хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцож байх зөвлөмжийг хүргүүлэв.



Аудитын илрүүлэлт

Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн бүрэлдэхүүн 4 буюу “Болзошгүй онцгой нөхцөл, гамшгийн үед хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн хэсэг”-т хүчит тэжээлийн дэмжлэгийг тэжээл үйлдвэрлэгчээс тээвэрлэгч, Улсын онцгой байдлын комиссоор дамжин малчдын гарт очих үйл явцыг хянах, удирдах зорилгоор түр хугацаатай гар утасны апплекейшн хөгжүүлсэн бөгөөд Баянхонгор аймгийн хэмжээнд нийт сумдын 12,970 малчин өрхөд нийт 3,112,810 кг өвс тэжээлийг тараасан ч уг апплейкешнд 12,007 малчин өрхөд нийт 2,881,680 кг өвс тэжээл нийлүүлсэн тайланг илгээсэн байна. Мэдээллийг зөрүүтэй оруулсан талаар Баянхонгор аймгийн ХХААГ-аас тодруулахад “дээрх зөрүүнд тайлбар хийх боломжгүй” гэсэн 1/245 дугаар албан бичгийг 2023.08.11-ний өдөр ирүүлсэн. Мөн Баянхонгор аймгийн ХХААГ-ын нягтлан бодогчоос тайлбар авахад “Ерөнхийдөө бүртгэлтэй утас нь холбогдохгүй, дугаараа сольсон, дугаар хаагдсан иймэрхүү нөхцөл байдлаас болоод бүрэн гүйцэт оруулаагүй” гэсэн тайлбарыг өгсөн болно.

Иймд салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулах зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

БҮЛЭГ В. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ САЙД, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД ОЛОН УЛСЫН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРӨӨР ОРОН НУТАГТ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТУСГААГҮЙГЭЭС ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

В.1.Зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд орон нутгийн байгууллагуудаас хяналт тавих чиг үүрэг байхгүй байна.

В.1.1. Олон улсын төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд хяналт тавих, удирдлагаар хангах гол үүргийг ХХААХҮЯ хариуцдаг, харин төсөл хэрэгжүүлэгч нэгж нь тогтсон хугацаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцдог байна.

Төсөл арга хэмжээний хяналт, үр дүнгийн талаар мэдээллийн Бүлэг В-г “Экспортыг дэмжих төсөл”-ийн www.edp.mn, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн www.lcp.mn, ХХААХҮЯ-ны www.mofa.gov.mn, ҮАГ-ын www.audit.mn, Шилэн дансны нэгдсэн цахим хуудас shilendans.gov.mn зэрэг вэб сайтууд, Үндэсний аудитын газрын Microsoft teams-т байршуулсан төсөл хөтөлбөрүүдийн тайлан, мэдээ, мэдээлэлд үндэслэн бэлтгэв.

ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжиж буй Экспортыг дэмжих төслийн бүрэлдэхүүн 2.3 “Түншлэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд мэдээллийг олон нийт, харилцагч талуудад ил тод хүртээмжтэй байлгах зорилгоор төслийн зар, мэдээ мэдээллийг төслийн албан ёсны вэйб сайт www.edp.mn -ийг хөгжүүлэн ашиглаж байна.

Тус цахим сайтад Баянхонгор аймагт хэрэгжиж буй тус төслийн бүрэлдэхүүн 2.3 “Түншлэлийн хөтөлбөр”-т хамрагдсан “Баялаг-Өлзий” ХХК, “Их халбагант” ХХК-ийн санхүүгийн дэмжлэгийн талаарх мэдээллийг байршуулсан байна.

Хүснэгт 7. Экспортыг дэмжих төслийн цахим системд байршуулсан мэдээлэл (сая.төг)

ААНБ-ын нэр	Түншлэлийн гэрээний дүн	Зарцуулалт	Мэдээлсэн эсэх
“Баялаг-Өлзий” ХХК	69.7	22.2	Тийм
“Их халбагант” ХХК	10.0	10.0	Тийм
“Урт наст эх” ХХК	48.6	0	Тийм

Эх сурвалж: “Экспортыг дэмжих төсөл”-ийн албан ёсны вэйб сайт www.edp.mn



Мөн нийгмийн сүлжээнд /фэйсбүүк хуудас, youtube суваг/ тогтмол нийтэлж, зар, мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэсэн байна.

Тус төслийн Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлсэн байдлыг “Грант Тронтон аудит” ХХК шалгасан бөгөөд 2021 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг байгууллагын шилэн дансны цахим хуудаст хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулах албан шаардлага, 2022 онд гүйцэтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар цахим хуудаст ил тод байршуулах мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлж ажиллаагүй тул холбогдох албан тушаалтнуудад сахилгын хариуцлага тооцох албан шаардлагыг тус тус хүргүүлсэн байна.

ХХААХҮЯ-аас 2020 онд хийсэн хяналт шинжилгээний тайланд Шилэн дансны тухай хууль, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу холбогдох мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулаагүй ба нөхөн байршуулсан боловч зарим мэдээлэл дутуу байршуулсан, мөн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг shilendans.gov.mn, tender.gov.mn хуудсанд байршуулаагүй зэрэг зөрчилд зөвлөмж өгч ажилласан байна.

“Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд төслийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод явуулах, сурталчлах төслийн албан ёсны вэйб сайт www.Lcp.mn цахим хуудсыг ашиглаж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл” нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудас shilendans.gov.mn болон Сангийн яамны Төслийн удирдлагын мэдээллийн сангийн ODAMIS системд мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

В.1.2. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй экспортыг дэмжих төсөл, МААЭЗЭН төслийн 2020, 2021, 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хуулийн цаглаварт хугацаанд заасны дагуу “Грант Торнтон аудит” ХХК, “Далай ван аудит” ХХК-ууд санхүүгийн тайлангийн аудитыг хийж, аудитаар илэрсэн зөрчилд дараах албан шаардлага, зөвлөмжийг өгсөн бөгөөд Баянхонгор аймгийн хэмжээнд илэрсэн зөрчлүүдийг тусад нь авч үзэх боломжгүй байв.

Хүснэгт 8. Төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчил (сая.төг)

Он	Зөвлөмж		Албан шаардлага		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020	2	1.1	3	30.6	5	31.7
2021			2	1,214.8	2	1,214.8
2022	1	1.1	3	1.9	4	2.9
Дүн	3	2.2	8	1,247.3	11	1,249.5
МААЭЗЭН төсөл /“Грант Торнтон аудит” ХХК/						
Он	Зөвлөмж		Албан шаардлага		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2020	2	8.5	1	0	3	8.5
2021	2	20.0	3	54,432.2	5	54,452.2
2022			3	312.1	3	312.1
Дүн	4	28.5	7	54,744.3	11	54,772.8

**Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл /Далай ван аудит ХХК/**

Он	Зөвлөмж		Албан шаардлага		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2019	2	0			2	0
2021			3	10,228.9	3	10,228.9
2022	2	0			2	0
Дүн	4	0	3	10,228.9	7	10,228.9

Эх сурвалж: УАГ-ын цахим сайт audit.mn

Экспортыг дэмжих төслийг 2017-2018 онд Сангийн яам, 2022 оноос ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжүүлж байгаа бөгөөд үйл ажиллагаа, гүйцэтгэл, үр дүнд бодитой үнэлэлт дүгнэлт өгч төслийн цаашдын үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулах зорилгоор үр дүнд суурилсан үнэлгээний арга болон хамтарсан үнэлгээний аргуудаар тус тус үнэлгээ хийж, хэрэгжилтийг 69.1-90 хувьтай дүгнэсэн байна.

Баянхонгор аймгийн ХХААГ-аас төсөл, хөтөлбөрүүдийн талаар судалгаа авахад дараах тайлбарыг ирүүлсэн.

Тайлбар

- “Олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр орон нутгийн Хөдөө аж ахуйн салбарт хийгдэж байгаа төсөл арга хэмжээний мэдээлэл манай газарт ирдэггүй, сонгон шалгаруулахдаа мэргэжлийн чиглэлийн байгууллагуудыг оролцуулдаггүй зэргээр ашиглалт болон үр өгөөжтэй хэрэгжихэд эрсдэл үүсгэдэг. Мөн төсөл арга хэмжээний явц, үр дүнд хяналт-шинжилгээ хийх байгууллага нь тодорхойгүй байна” гэсэн тайлбарыг Баянхонгор аймгийн ХХААГ-ын 2023.06.02-ны өдрийн 1/182 дугаар албан бичгээр ирүүлсэн.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2016-2022 оны гэрээний хэрэгжилтийг шалгахад олон улсын төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг тус хамтран ажиллах гэрээнд тусгаагүй, холбогдох орон нутгийн байгууллагуудад хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг байхгүйгээс хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцоогүй, хяналт шалгалт хийгээгүй тул аудитад орон нутгийн байгууллагаас хийсэн хяналтын тайлан, мэдээ, мэдээлэл олдоогүй болно.

Иймд цаашид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд, аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд олон улсын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах, орон нутагт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагад хяналт тавих, үр дүнг тооцсон хяналт-шинжилгээний тайланг яаманд ирүүлэх чиг үүргийг шилжүүлж, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх саналыг УАГ-ын дамжуулан ХХААХҮЯ-нд уламжлав.

В.2 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд журамд заасны дагуу жил бүр үнэлж, үр дүнг тооцсон байна.

В.2.1. ХХААХҮЯ-ны дэргэд хэрэгжиж буй “Экспортыг дэмжих төсөл” нь 2016-2023 он, “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл” нь 2020-2025 он, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт” төсөл нь 2016-2021 он хүртэл хэрэгжихээр төлөвлөжээ.

Дээрх төсөл хөтөлбөрүүдэд МУЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу төлөвлөсөн арга



хэмжээний гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан, тэдгээрийн хоорондын зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулах, бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулж, гадаад зээлийн үр дүн, үр ашиг, ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас Хяналт шинжилгээ-үнэлгээг үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 9. Олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний тайлан 2020-2022 он

Тайлант он	МАЗЭЗЭН төсөл /2020-2025 он/		Экспортыг дэмжих төсөл /2016-2023 он/		Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт /2016-2021 он/	
	Хэрэгжилтийн хувь	Өгсөн зөвлөмжийн тоо	Хэрэгжилтийн хувь	Өгсөн зөвлөмжийн тоо	Хэрэгжилтийн хувь	Өгсөн зөвлөмжийн тоо
2020	80.4	6	68.8	5	86.5	0
2021	83.5	1	74.1	4	97.5	5
2022	83.5	1	Үнэлгээ хийсэн материал олдоогүй		94.0	7

Эх сурвалж: ХХААХҮЯ-ны www.mofa.gov.mn сайтад байршуулсан ХШҮ-ний тайлан

ХХААХҮЯ-аас 2020-2021 онд хийсэн хяналт шинжилгээ-үнэлгээний тайланд МАЗЭЗЭН төсөл нь 80.4-83.5 хувь, “Экспортыг дэмжих төсөл” нь 68.8-74.1 хувь, “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн Нэмэлт санхүүжилт төсөл” 86.5-97.5 хувийн биелэлттэйгээр үнэлэгдсэн байна.

“Экспортыг дэмжих төсөл”-ийн хэрэгжилтийн хувьд экспортын өсөлт зорилтот түвшинд хүрэхгүй, доогуур үзүүлэлттэй байгаа нь цар тахлын хөл хорио, хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан ААН-үүд экспортын үйл ажиллагаагаа хумих, зогсоох зэрэг арга хэмжээ авч байсантай холбоотой гэсэн ба 2022 онд үйл ажиллагаа хэвийн болж эхэлснээр экспорт эргээд өсөж байгаа нөхцөл байдалтай гэж тайлагнасан байна.

В.2.2. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн төгсгөлийн тайланд ХХААХҮЯ-аас хийсэн Хяналт шинжилгээ-үнэлгээгээр “Төслийн хүрээнд 2017-2020 онд худалдан авч нийлүүлсэн бараа материал, тоног төхөөрөмж, аймгуудад гарган өгсөн худгуудыг ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгөх ажлыг ХХААХҮЯ болон ашиглагч байгууллагуудтай хамтран зохион байгуулж дуусгах” гэж зөвлөмж өгсөн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.09.16-ны өдрийн “Үндсэн хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай” 10/44 дүгээр тогтоолд “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл”-өөр Баянхонгор аймгийн Бууцагаан, Шинэжинст, Жинст, Баацагаан, Баянговь сумдад 2020, 2021 онд хийж, ашиглалтад орсон инженерийн хийцтэй 124.6 сая төгрөгийн өртөг бүхий 5 ширхэг худгийг сумдын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэх шийдвэр гарсан байна.

Хүснэгт 10. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийн жагсаалт (сая.төг)

№	Хөрөнгийн нэр	Эзэмшигч байгууллага	Хөрөнгөд бүртгэсэн огноо	Бүртгэх хөрөнгийн дүн
1	Мэлхийн нурууны худаг	Жинст сумын ЗДТГ	2022.10.19	27.5



Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж

2	Жалангарын худаг	Бууцагаан сумын ЗДТГ	2022.11.01	24.7
3	Товгор 5- баг хөрөнгийн тал	Баацагаан сумын ЗДТГ	2022.10.19	23.2
4	Урд бяцхан худаг	Баянговь сумын ЗДТГ	2022.10.19	24.4
5	Худаг	Шинэжинст сумын ЗДТГ	Бүртгээгүй	24.7
ДҮН				124.6

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022.09.16-ны өдрийн тогтоол болон хөрөнгө эзэмшигч байгууллагуудаас ирүүлсэн хөрөнгийн журнал

Аудитын илрүүлэлт

- Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл"-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 24.7 сая төгрөгийн өртөг бүхий инженерийн хийцтэй худгийг байгууллагын хөрөнгөд тусгаагүй байна.

Иймд дээрх 24.7 сая төгрөгийн үнэ бүхий инженерийн хийцтэй худгийг байгууллагын хөрөнгөд бүртгэх албан шаардлагыг Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 316.4 сая төгрөгийн 4 зөрчил илэрсэнд 291.7 сая төгрөгийн 3 заалт бүхий зөвлөмжийг холбогдох 2 тушаалтанд, 24.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг Шинэжинст сумын ЗДТГ-т хүргүүлж, УАГ-аар дамжуулан ХХААХҮЯ-д 2 саналыг уламжлав.



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Тайлангийн төслийг аймгийн Засаг дарга, аймгийн ХХААГ, МЭГ-т хүргүүлсэн, тайлангийн төсөлд санал ирээгүй болно.

**БЯАНХОНГОР АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР**
402 дугаар байр Рашаантын гудамж 4
Рашаант 10 дугаар баг Баянхонгор сум
Баянхонгор аймаг 54107
Утас: (976) 70644017, 70642478
Цахим хуудан: hhaag.bxni.gov.mn

Хүснэгт № 1/2019
Танай 2023.08.17 -нөм. № 21391 -Т

**БЯАНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг уншиж танилцсан бөгөөд манай байгууллагатай холбоотой саналгүй болно.

ҮЙЛДВЭР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
АЛБАНЫ ДАРГА Б.МӨНХТОГТОХ

642316716

**БЯАНХОНГОР АЙМГИЙН
МАЛ ҮНДЭТГИЙН ГАЗАР**
402 дугаар байр Рашаантын гудамж 4
Баянхонгор сум Баянхонгор аймаг 54107
Утас: 70642478
Цахим хуудан: hhaag.bxni.gov.mn

Хүснэгт № 1/2019
Танай 2023.08.17 -нөм. № 21391 -Т

Санал хүргүүлэх тухай

Төсөл хэрэгжсэн сүмдэд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан байна. Цаг үеийн ажлын нөхцөл байдал өтөр нүүдэл, өвөлжилтийн байдлаас шалтгаалан аль болох сумын төвийн бус мал малладаг малчдыг хялруулан малчид хотонд болон зар хурган сумын төвд цуглуулан гарын авлага, материалыг тараан малчид хүрсэн халдварт гоц халдварт өөчний халдварлалт эсцэдэл өндөр цаг үед хэрэгцээ шаардлага мэдээллийг хангасан үр дүнтэй сургалт болсон гэж үзэж байна.

Сургалтад хамрагдсан малчдын бүртгэл, ажлын тайланг <https://mns.lcp.mn> цахим системд оруулж Төслийн байгууллагаас тухай бүр татан авч боловсруулалтыг хийсэн байна. Бүртгэлийн хуудсанд тооны зөрүүтэй байгаа нь бичиг үсгийн мэдээгүй хуудас явуулах үед байгаагүй үлдсэн байх магадлалтай байна гэж үзэж байна. Сум орон нутгийн удирдлагууд маш сайнаар хүлээн авч сургалтад малын эмч мэргэжилтэн нартай хамт малчдад өгсөн мэдээллийг сонсож байна.

Төслийн зүгээс нэгдсэн боловсруулалт хийн үр дүн тайлан мэдээг нэгтгэн танилцсан байна.

Цаашид өгсөн зөвлөмжийн дагуу хэсэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрт зардал нь таливдан шийдвэрлэгдвэл хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахад бэлэн байна.

ДАРГА Д.ОЮУН-ЭРДЭНЭ

642203040
ХТ 6681 2023.08



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан тусламжийн хөрөнгөөр урт, дунд, богино хугацааны бодлого, чиглэлийг үндэслэн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, цаг үеэ олсон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дэргэд хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд холбогдох байгууллага журамд заасны дагуу жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцож, холбогдох тайлан, мэдээ мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна.
3. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд, аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд олон улсын төсөл хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг тусгаагүй, холбогдох орон нутгийн байгууллагуудад хяналт хэрэгжүүлэх чиг үүрэг байхгүйгээс хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнг тооцоогүй, хяналт шалгалт хийгээгүй байна.
4. Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслөөс малчдад зориулсан сургалтыг хөтөлбөрт заасан хугацаанд хэрэгжүүлээгүй, удирдамжид заасны дагуу эмэгтэй малчдыг хамруулаагүй байна.
5. Баянхонгор аймгийн Шинэжинст сумын ЗДТГ нь “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэмэлт санхүүжилт төсөл”-ийн үр дүнд бий болсон 24.7 сая төгрөгийн өртөг бүхий инженерийн хийцтэй худгийг хөрөнгөд бүртгээгүй байна.



ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАРТ

1. Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож, хяналт тавьж тавьж ажиллан аймаг орон нутгийн удирдлагыг мэдээллээр бүрэн ханган ажиллах

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАРТ

1. Олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож, хяналт тавьж ажиллан аймаг орон нутгийн удирдлагыг мэдээллээр бүрэн ханган ажиллах
2. Салбарын хэмжээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулж байх

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААР ДАМЖУУЛАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

1. Орон нутагт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох мэргэжлийн байгууллагад хяналт тавих, үр дүнг тооцсон хяналт-шинжилгээний тайланг яаманд ирүүлэх чиг үүргийг шилжүүлж, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх
2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайд, аймгийн Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд олон улсын төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж, үр дүнд хяналт тавин тайлагнаж байх талаар оруулах

---oOo---